



ЭРҮҮЛ
МЭНДИЙН ЯАМ



THE WORLD BANK
IBRD • IDA | WORLD BANK GROUP

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ КОМПАНИ МЭДҮҮЛГИЙН УРИЛГА

(Зөвлөх сонгох чадварын арга (ЗСЧА) дээр үндэслэнэ)

Дэлхийн банкны зээлийн дугаар:	6833-MN
Төслийн нэр:	Монгол улсад КОВИД-19 халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах төсөл
Зөвлөх үйлчилгээний нэр:	Төслийн хүрээнд нийлүүлсэн тоног төхөөрөмжийн үр ашгийн судалгаа / тоног төхөөрөмжийн аудит
Гэрээ дугаар:	CS10

Дэлхийн банкны хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Монгол Улсад КОВИД-19 халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах” төслийн хүрээнд энэ гэрээг санхүүжүүлнэ.

Энэхүү сонгон шалгаруулалтыг Эрүүл мэндийн яамнаас зохион байгуулах бөгөөд сонгон шалгаруулалтад оролцох сонирхолтой этгээдүүд baasanbayar@ehp.mn цахим шуудан руу хүсэлт ирүүлнэ. Сонирхсон этгээдийн ирүүлсэн хүсэлтийн дагуу Ажлын даалгаврыг багтаасан Мэдүүлгийн урилгын баримт бичгийг цахим шуудангаар илгээнэ.

Сонгон шалгаруулалтыг Зөвлөх сонгох чадварын аргаар явуулах бөгөөд Дэлхийн банкнаас 2020 оны 11 дүгээр сард баталсан “Худалдан авах ажиллагааны журам” (“Procurement Regulations for IPF Borrowers” November 2020 edition - “Procurement Regulations”) -ын дагуу хэрэгжүүлнэ. Тус журамд заасан эрх бүхий бүх этгээдүүд сонгон шалгаруулалтад оролцох боломжтой.

Чадварыг нэмэгдүүлж сайжруулах зорилгоор зөвлөх нь өөр хуулийн этгээдтэй хамтран хамтран оролцож болно. Хамтран оролцож буй зөвлөх нь түншлэлийн, эсхүл туслан гүйцэтгэгчийн хэлбэрээр оролцож буй эсэхийг тодорхой зааж ирүүлнэ. Түншлэлээр оролцож буй зөвлөх нь гэрээний хэрэгжилтийн дангаар болон тус тусдаа хариуцна.

Зөвлөх үйлчилгээ нь (1) Үндсэн даалгавар (2) Нэмэлт даалгавар гэсэн хоёр ажлын хүрээнд хэрэгжинэ. Ажлын үндсэн даалгаврыг гэрээ байгуулан гүйцэтгэнэ. Уг гэрээний гүйцэтгэл, төслийн хугацаа сунгалт зэргээс хамааран талууд Нэмэлт даалгаврыг багтаасан гэрээний нэмэлт өөрчлөлтийг батлах боломжтой. Байгууллагууд сонгон шалгаруулалтад оролцох сонирхлоо ирүүлэх бөгөөд техникийн санал, үнийн саналд Үндсэн даалгавар болон Нэмэлт даалгаврыг тус тус хамруулна. Хоёр ажлын үнийн саналын нийлбэр дүнгээр Эрүүл мэндийн яамнаас сонгон шалгаруулалтад оролцогчийг үнэлнэ. Эрүүл мэндийн яамнаас Нэмэлт

ажлын үнийн саналыг үнэлэх нь энэхүү ажлыг заавал хэрэгжүүлэх үндэслэл болохгүй.

Зөвлөх нь ашиг сонирхолын талаар дурдсан Дэлхийн банкны худалдан авалтын журмын III-р бүлгийн 3.14, 3.16 зүйлийг уншиж танилцсан байна - “Procurement Regulations for IPF Borrowers” November 2020 (“Procurement Regulations”), <https://thedocs.worldbank.org/en/doc/178331533065871195-0290022020/original/ProcurementRegulations.pdf>

Дор дурдсан хаягт ажлын цагаар хандаж нэмэлт мэдээлэл авч болно.

Өргөдөл ирүүлэх:

Сонирхсон этгээдүүд 2024 оны 07 дугаар сарын 24-ны өдрийн Улаанбаатар хотын цагаар 16:00 цагаас өмнө baasanbayar@ehp.mn цахим шуудангаар сонгон шалгаруулалтад оролцох сонирхол / мэдүүлгээ ирүүлнэ. Захиалагч заасан хугацаанаас хойш ирүүлсэн мэдүүлгийг хүлээн авахгүй.

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпийн гудамж 5, Аюуд тауэр, 11 давхар, 1103 тоот, Төсөл хэрэгжүүлэх нэгж
Вэб сайт: <http://ehp.mn> , имэйл: baasanbayar@ehp.mn

АЖЛЫН ДААЛГАВАР
ТӨСЛИЙН ХҮРЭЭНД НИЙЛҮҮЛСЭН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ҮР АШГИЙН
СУДАЛГАА – CS10

1. ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Эрүүл мэндийн яам нь Монгол улсад КОВИД-19 халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах төслийг хэрэгжүүлж байна. Уг төслийн хүрээнд 84 гэрээгээр нийт 29 сая ам. долларын төсөвтэй 5 мянга гаруй эмнэлгийн тоног төхөөрөмжийг нийлүүлсэн. Эдгээр тоног төхөөрөмжүүдийг хүлээлгэн өгч, суурилуулж, ашиглалтад оруулснаас хойш тодорхой хугацаа өнгөрсөн тул ЭМЯ-аас төслийн хүрээнд нийлүүлсэн тоног төхөөрөмжийн судалгаа, хөрөнгө оруулалтын үр ашгийн судалгаа / аудит хийхээр төлөвлөж байна.

2. ЗОРИЛГО

- 2.1. Эрүүл мэндийн яам нь Үндсэн даалгавар болон Нэмэлт даалгаврын нийт үнийн дүнгээр Зөвлөх үйлчилгээний сонгон шалгаруулалтыг хийнэ. Эрүүл мэндийн яамнаас Нэмэлт ажлын үнийн саналыг үнэлэх нь энэхүү нэмэлт ажлыг заавал хэрэгжүүлэх үндэслэл болохгүй.

- 2.2. Монгол улсад КОВИД-19 халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах төслийн хүрээнд худалдан авч, нийлүүлсэн тоног төхөөрөмжийн үр ашгийг судлах бие даасан судалгаа/аудит хийхдээ дараах ажлыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

- 1) Төслийн хүрээнд нийлүүлсэн тоног төхөөрөмжийг хуваарилсан байгууллагад хүлээлгэн өгсөн эсэхийг шалгах;
- 2) Тоног төхөөрөмжийн хүргэлт, суурилуулалтын чанарыг шалгах;
- 3) Гэрээнд заасан бол зохион байгуулсан тоног төхөөрөмжийн сургалт нь чанартай байсан эсэхийг шалгах;
- 4) Чанарын баталгааны нөхцөлийг хангасан эсэхийг шалгах;
- 5) Засвар үйлчилгээний нөхцөлийг шалгах;
- 6) Борлуулалтын дараах үйлчилгээ хийгдсэн эсэх;
- 7) Тоног төхөөрөмжийн хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн судалгааг хийх;
- 8) Тухайн байгууллага дахь тоног төхөөрөмжийн ашиглалтыг шалгах;
- 9) Үйл ажиллагааны төсөв нь хангалттай эсэх талаар магадлах.

3. ХАМРАХ ХҮРЭЭ

- 3.1. Зөвлөх нь Захиалагчаас дараах баримт бичгүүдийг хүлээн авч, хянан, Ерөнхий жагсаалтыг хийж гүйцэтгэнэ.

- 1) Эмнэлгийн тоног төхөөрөмж худалдан авах, хүргэх гэрээ - Гэрээнд нэгжийн үнэ, тоо ширхэг, нийт үнэ, тоног төхөөрөмжийн брэнд, загвар, техникийн үзүүлэлт, дагалдах сэлбэг, хэрэгсэл, чанарын баталгааны шаардлага, сургалтын шаардлага, ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлага зэргийг тусгасан байна.
- 2) Эмнэлгийн тоног төхөөрөмж хүлээлцэх акт, Чанарын баталгааны хуудас, Сургалт, засвар үйлчилгээний хуваарь

- 3) Эрүүл мэндийн сайдын тоног төхөөрөмж орлогод авч, хуваарилах тушаал - Тушаалын хавсралтаар тоног төхөөрөмжийн нэр, брэнд, загвар, үнэ, хуваарилах эмнэлгийг заасан байна (Нийт 40 орчим тушаал).
- 3.2. Зөвлөх нь 3.1.1-3.1.3-д заасан бүх тоног төхөөрөмжийн мэдээллийг нэгтгэн, (CMMS эсвэл ижил төрлийн өгөгдлийн санд суурилсан) Ерөнхий жагсаалтыг бэлтгэн гүйцэтгэнэ. **БҮТЭЭГДЭХҮҮН – 1.**
- 3.3. Зөвлөх нь Ерөнхий жагсаалтад үндэслэн төслийн хүрээнд нийлүүлсэн тоног төхөөрөмжийн мэдээллийг цуглуулах зорилгоор мэдээлэл цуглуулах арга хэрэгсэл боловсруулна. Энэхүү мэдээлэл цуглуулах арга хэрэгслийг мөн тоног төхөөрөмжийн гүйцэтгэл, үр дүнг хэмжихэд ашиглаж болно. Судалгааны асуумжийг 0-5 оноогоор үнэлэх систем, эсвэл Тийм/Үгүй гэсэн хариулттай асуумжаар хийвэл зохистой. Судалгааны ажлыг нэгтгэх, дүн шинжилгээ хийх, тайлагнах, үр дүнг оновчтой болгохын тулд Kobo toolbox, PowerApps Microsoft зэрэг судалгааны программыг ашиглах нь зохистой.
- 3.4. Мэдээлэл цуглуулах арга хэрэгсэл нь хамгийн багадаа (доорх жагсаалтаар хязгаарлагдахгүй болно) дараах мэдээллүүдийг багтаасан байна.
- 1) Тоног төхөөрөмж, барааны үндсэн мэдээлэл
 - a. Хуваарилсан эмнэлгийн нэр
 - b. Эмнэлгийн нэр, хаяг
 - c. Эмнэлгийн түвшин – Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, Дүүргийн Эрүүл мэндийн төв, Нэгдсэн эмнэлэг, Аймгийн Нэгдсэн эмнэлэг, Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, Сумын Эрүүл мэндийн төв
 - d. Эмнэлэг нь тухайн тоног төхөөрөмжийг хариуцан ажиллуулдаг инженер, техникийн ажилтны эсэх
 - e. Тоног төхөөрөмж хариуцсан инженер, техникийн ажилтны холбоо барих мэдээлэл
 - f. Эмнэлгийн тоног төхөөрөмж, эд хөрөнгийн эрүүл мэндийн салбарын нэгдсэн бүртгэлийн HEPS цахим системд нэврэх эрхийг Зөвлөхөд олгох ба Зөвлөх нь уг системд төслийн хүрээнд нийлүүлсэн тоног төхөөрөмж, бараа нь бүртгэгдсэн эсэхийг шалгана. Энэ үйл ажиллагаа нь төслийн хүрээнд нийлүүлсэн тоног төхөөрөмжийг үндсэн хөрөнгөд бүртгээгүй, шамшигдуулсан эсэхийг илрүүлэх зорилготой болно.
 - 2) Нийлүүлэгчийн үндсэн мэдээлэл
 - a. Нийлүүлэгчийн нэр, хаяг, утас, цахим шуудан, вэб сайт
 - b. Хариуцсан ажилтны холбоо барих мэдээлэл
 - 3) Гар багаж, хэрэгсэл, тавилга, компьютер, гал тогооны тоног төхөөрөмж, пульсоксиметрээс бусад эмнэлгийн тоног төхөөрөмж тус бүрийн үндсэн мэдээлэл:
 - Суурилуулсан эмнэлгийн нэр
 - Суурилуулсан эмнэлгийн газар, нэгжийн нэр
 - Тоног төхөөрөмжийн нэр
 - Үйлдвэрлэгчийн нэр / брэнд
 - Загвар

- Серийн дугаар
 - Үйлдвэрлэсэн улс
 - Үйлдвэрлэсэн он
 - Нэгжийн үнэ
 - Нийлүүлэгч байгууллагын нэр
 - Гэрээний дугаар
 - Эрүүл мэндийн яамны тушаалын дугаар
 - Эрүүл мэндийн яамны тушаалын огноо
 - Хүргэгдсэн огноо
 - Суурилуулсан огноо
 - Чанарын баталгааны дуусах хугацаа
 - Тоног төхөөрөмжид хэрэглээний материал шаардлагатай эсэх (Тийм / Үгүй)
 - Тоног төхөөрөмжийг эмнэлгийн хөрөнгөд бүртгэсэн эсэх
- 4) Гар багаж, хэрэгсэл, тавилга, компьютер, гал тогооны тоног төхөөрөмж, пульсоксиметрээс бусад эмнэлгийн тоног төхөөрөмжийн хүргэлт, суурилуулалтын үйл ажиллагааны чанарт хяналт, шалгалт хийх:
- Тоног төхөөрөмжийг журмын дагуу зөв нийлүүлж, суурилуулсан уу?
 - Тоног төхөөрөмжид шаардлагатай бүх дагалдах хэрэгсэл ирсэн үү? (Тийм/Үгүй)
 - Тоног төхөөрөмж нь нэмэлт сэлбэг хэрэгсэлтэй ирсэн үү? (Тийм/Үгүй)
 - Тоног төхөөрөмж ашиглалтын гарын авлага ирсэн эсэх
 - Тоног төхөөрөмжийн хамт засвар үйлчилгээний гарын авлага ирсэн эсэх
 - Гарын авлага ямар хэл дээр байсан бэ? (өөр өөр хэлний сонголтуудыг хариулт хэсэгт оруулах)
 - Суурилуулсны дараа төхөөрөмжид ямар нэгэн асуудал гарсан уу?
 - (Тийм бол) Асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн бэ?
 - Тоног төхөөрөмжийн одоогийн нөхцөл байдал хэвийн эсэх
 - Одоогоор төхөөрөмжтэй холбоотой ямар нэгэн асуудал байгаа юу? (сонголттой хариулт)
 - Тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний гэрээ байгаа юу? (Тийм/Үгүй)
 - Хэрвээ тоног төхөөрөмжийг ашиглахад нэг удаагийн хэрэгсэл шаардлагатай байдаг бол эдгээр нь бэлэн байгаа юу? (Тийм/Үгүй)
 - Үгүй бол яагаад? (сонголттой хариулт)
 - Хангамж, материалын чанарт үнэлгээ өгнө үү.
- 5) Гар багаж, хэрэгсэл, тавилга, компьютер, гал тогооны тоног төхөөрөмж, пульсоксиметрээс бусад эмнэлгийн тоног төхөөрөмжид сургалтын үйл ажиллагааг шаардсан бол сургалтын чанарыг шалгах:
- Сургалт хийгдсэн эсэх
 - Сургалт нь гэрээнд заасан шаардлагын дагуу хэрэгжсэн эсэх
 - Эмч/сувилагч нь тоног төхөөрөмжийг бүрэн ашиглахад шаардлагатай мэдлэгтэй эсэх

- Инженер, техникийн ажилчид тоног төхөөрөмжийн сургалтад хамрагдсан эсэх
 - Инженер, техникийн ажилчид шаардлагатай тохиолдолд тоног төхөөрөмжийг засварлах чадвартай болсон эсэх
- 6) Гар багаж, хэрэгсэл, тавилга, компьютер, гал тогооны тоног төхөөрөмж, пульсоксиметрээс бусад эмнэлгийн тоног төхөөрөмжийн чанарын баталгаанд судалгаа хийх:
- Тоног төхөөрөмжийн чанарын баталгаат хугацаа нь хүчинтэй хэвээр эсэх
 - Хэрэв чанарын баталгааны хугацаа дууссан бол энэ чанарын баталгаа нь амжилттай байсан эсэх
 - Хэрэв хангалтгүй / амжилтгүй гэж үзвэл дэлгэрэнгүй тайлбарлана уу.
 - Ямар нэгэн эвдрэл гэмтэл гарсан эсэх
 - Хэрэв эвдрэл гэмтэл гарсан бол нийлүүлэгчээс эвдрэлийг засахад дунджаар хэр хугацаа зарцуулсан бэ? (Асуултын хариулт нь хэд хэдэн сонголттой байх). Гэмтлийн шалтгааныг тодорхой бичүүлэх 1, Цахилгааны хэлбэлзэл, 2. Ашиглагчийн буруутай үйл ажиллагаа, 3. Хугацаанд нь сэлбэг солиогүйгээс үүссэн гэх мэт
 - Нийлүүлэгч засвар үйлчилгээ үзүүлэхдээ эвдрэл гарсан газарт ирж ажилласан уу? эсвэл цахимаар дэмжлэг үзүүлэн ажилласан уу? (аль нэг нь эсвэл аль аль нь гэсэн сонголттой байх)
- 7) Гар багаж, хэрэгсэл, тавилга, компьютер, гал тогооны тоног төхөөрөмж, пульсоксиметрээс бусад эмнэлгийн тоног төхөөрөмжийн ашиглалтад хяналт хийх
- Тоног төхөөрөмжийг хүргэж/суурилуулснаас хойш үзлэг/эмчилгээ хийлгэсэн өвчтөний тоо
 - Сард дунджаар үзлэг/эмчилгээ хийлгэсэн өвчтөний тоо
 - Суурилуулснаас хойших хугацаанд төхөөрөмж нийт хэдэн цаг ажилласан бэ? (Зарим төхөөрөмж дээр энэ мэдээллийн гаргах боломжгүй байж болно)
 - Хэрэв төхөөрөмжид эвдрэл, гэмтэл гарч байсан бол засварлах хүртэл хэдий хугацаанд төхөөрөмжийг ашиглаагүй вэ?
 - Хэрвээ тоног төхөөрөмжийг ашиглахад нэг удаагийн хэрэгсэл шаардлагатай байдаг бол эдгээр нь бэлэн байгаа юу?
 - Нэг удаагийн хэрэгслийг худалдан авах хангалттай хэмжээний төсөв байгаа эсэх
- 8) Гар багаж, хэрэгсэл, тавилга, компьютер, гал тогооны тоног төхөөрөмж, пульсоксиметрээс бусад эмнэлгийн тоног төхөөрөмжийн засварын мэдээлэл:
- Тоног төхөөрөмжийн баталгаат хугацаанд нийлүүлэгч засвар үйлчилгээ хийсэн эсэх
 - Хэрэв тийм бол нэг жилд хэдэн удаа засвар үйлчилгээ хийсэн бэ?
 - Нийлүүлэгч тоног төхөөрөмжийн засвар, үйлчилгээг жилд хэдэн удаа хийх ёстойг та мэдэх үү?

- Тоног төхөөрөмжид засвар хийх сэлбэг, хэрэгсэл байгаа юу?
 - Тоног төхөөрөмжид засвар хийх сэлбэг, хэрэгслийг худалдан авах төсөв байгаа юу?
 - Тоног төхөөрөмжид засвар, үйлчилгээ хийхэд ашиглах сэлбэг, хэрэгслээр хангахад нийлүүлэгч тусалцаа үзүүлдэг үү?
- 9) Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын эмнэлгийн шалгалт тохируулгад хамрагдсан эсэх тухай мэдээлэл
- 10) Хэрэв эмнэлгийн зүгээс Төсөлд 1-5 хүртэлх оноогоор үнэлгээ өгвөл
- a. Нийлүүлсэн тоног төхөөрөмжийн нэр төрлийг хэдэн оноогоор дүгнэх вэ?
 - b. Нийлүүлсэн тоног төхөөрөмжийн чанарыг хэдэн оноогоор дүгнэх вэ?
 - c. Нийлүүлэгчийг хэдэн оноогоор дүгнэх вэ?
 - d. Тоног төхөөрөмжийн сургалтыг хэдэн оноогоор үнэлэх вэ?
- 3.5. Зөвлөх нь Мэдээлэл цуглуулах арга хэрэгслийг боловсруулж, Захиалагчаар хянуулж, баталгаажуулна. **БҮТЭЭГДЭХҮҮН 2.1.**
- 3.6. Зөвлөх нь Мэдээлэл цуглуулах арга хэрэгслийг дор дурдсан эмнэлгийн 100 орчим төхөөрөмж (жишээлбэл, 10 тарилгын автомат шахуурга, 10 өвчтөний хяналтын монитор, 5 зүрхний цахилгаан бичлэгийн аппарат гэх мэт)-д туршина.
1. Улсын гуравдугаар төв эмнэлэг
 2. Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв-2
 3. АШУҮИС-ийн харьяа Монгол-Японы эмнэлэг
- 3.7. Зөвлөх нь 3.6-д дурдсан өгөгдлүүд дээр Мэдээлэл цуглуулах арга хэрэгслийг туршин (өгөгдөл цуглуулж, мэдээллийн нэгтгэж, нэгдсэн дүн шинжилгээ хийх), судалгааны үр дүнг Захиалагчид хүлээлгэн өгнө. - **БҮТЭЭГДЭХҮҮН 2.2.**
- 3.8. Зөвлөх нь Мэдээлэл цуглуулах арга хэрэгслийн дагуу, дараах эмнэлгүүдэд судалгаа хийнэ.

ҮНДСЭН ДААЛГАВАР

1. Улсын гуравдугаар төв эмнэлэг (биечлэн ажиллах)
2. Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв-2 (биечлэн ажиллах)
3. АШУҮИС-ийн харьяа Монгол-Японы эмнэлэг (биечлэн ажиллах)
4. Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв – 2 эмнэлэг (биечлэн ажиллах)
5. Дүүргийн эмнэлэг – 4 (биечлэн ажиллах)
6. Аймгийн нэгдсэн эмнэлэг – 2 (Завхан, Орхон аймагт - биечлэн ажиллах)
7. Сумын эмнэлэг – 6 (Завхан аймаг, Дорноговь, Орхон аймагт - биечлэн ажиллах)
8. Халдварт өвчин судлалын үндэсний төвийн вакцины агуулах (биечлэн ажиллах)
9. Цуглуулсан судалгааны материалыг баталгаажуулах зорилгоор 18 аймгийн Нэгдсэн эмнэлэг, 40 сумын эмнэлгүүдтэй утсаар холбогдон, зайнаас судалгаа авна.

10. Зөвлөх нь Эмнэлгийн тоног төхөөрөмж, эд хөрөнгийн эрүүл мэндийн салбарын нэгдсэн бүртгэлийн NEPS цахим системийг сайжруулах талаар зөвлөмж өгнө.

Зөвлөх нь дээрх цуглуулсан мэдээлэл (цахим мэдээллийн сан) болон урьдчилсан статистик зэргийг нэгтгэн үйл ажиллагааны явцын тайланг боловсруулна.

НЭМЭЛТ ДААЛГАВАР (Үндсэн даалгавар дээр нэмэлтээр)

1. Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв – 4 эмнэлэг (биечлэн ажиллах)
2. Эрүүл мэндийн яамнаас бусад яамны харьяа 2 эмнэлэг (биечлэн ажиллах)
3. Дүүргийн эмнэлэг – 3 эмнэлэг (биечлэн ажиллах)
4. Аймгийн эмнэлэг – 4 эмнэлэг (Дорнод, Увс, Ховд, Өвөрхангай аймагт - биечлэн ажиллах)
5. Сумын эмнэлэг -12 эмнэлэг (Дорнод, Увс, Ховд, Өвөрхангай аймагт - биечлэн ажиллах)
6. Сумын эмнэлэг – 100 эмнэлэг (зайнаас судалгаа авах)

Зөвлөх нь дээрх цуглуулсан мэдээлэл (цахим мэдээллийн сан) болон урьдчилсан статистик зэргийг нэгтгэн үйл ажиллагааны явцын тайланг бэлтгэнэ.

3.9. Зөвлөх нь Мэдээлэл цуглуулах арга хэрэгслийг ашиглан цуглуулсан мэдээлэлд дүн шинжилгээ хийж, нэгдсэн тайланг боловсруулж, Захиалагчид хүлээлгэн өгнө. **БҮТЭЭГДЭХҮҮН 3.**

3.10. Зөвлөх нь дараах зүйлсийг Захиалагчид хүлээлгэн өгнө. **БҮТЭЭГДЭХҮҮН 4.**

1. Мэдээлэлд хийсэн дүн шинжилгээ, зөвлөмж бүхий Монгол хэл дээрх эцсийн тайлан.
2. Судалгааны үр дүн, сургамж, зөвлөмж зэргийг багтаасан Англи хэл дээрх 10 хуудас хураангуй тайлан.
3. Судалгааны бүх мэдээллийг багтаасан цахим мэдээллийн сан.
4. Мэдээллийн боловсруулах арга, хэрэгсэл

4. ЗАХИАЛАГЧИЙН ОРОЛЦОО БОЛОН ХАМТРАГЧ ТАЛУУД

4.1. Захиалагчаас Зөвлөхөд үзүүлэх үйлчилгээ, оффис талбай, эд хөрөнгө: Байхгүй

4.2. Захиалагчаас зөвлөхийн багт томилох мэргэжлийн болон туслах ажилтан: Төсөл хэрэгжүүлэх нэгж нь энэхүү гэрээг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэн ажиллана.

5. ХУГАЦАА

5.1. Зөвлөх үйлчилгээг 2024 оны 6 дугаар сарын 25-ны өдрөөс эхлүүлэхээр төлөвлөж байна.

Утга	Хэрэгжүүлэх хугацаа /Гэрээ байгуулсан өдрөөс хойш/	Гүйцэтгэгчид олгох гэрээний үнийн хувь
------	--	--

Даалгавар 0 – Ажиллах хүчин, гүйцэтгэх ажил, гүйцэтгэх шат дарааллыг багтаасан үйл ажиллагааны хэрэгжилтийн төлөвлөгөөг боловсруулах	7 хоногийн дотор	0%
Даалга 1 – Ерөнхий жагсаалтыг эцэслэн, Захиалагчаар батлуулах	20 хоногийн дотор	20%
Даалгавар 2.1 – Мэдээлэл цуглуулах арга хэрэгслийг боловсруулж, эцэслэх	35 хоногийн дотор	20%
Даалгавар 2.2 – Мэдээлэл цуглуулах арга хэрэгслийг Монгол-Японы эмнэлэгт туршиж, мэдээллийг нэгтгэн Захиалагчаар батлуулах	65 хоногийн дотор	
Даалгавар 3 – Нэгдсэн тайлан боловсруулж, Захиалагчаар батлуулах	- 80 хоногийн дотор - 130 хоногийн дотор (нэмэлт даалгавар)	20%
Даалгавар 4 - Захиалагчаар эцсийн тайланг батлуулах	- 90 хоногийн дотор - 190 хоногийн дотор (нэмэлт даалгавар)	40%

6. ХАНГАВАЛ ЗОХИХ ДООД ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

- 6.1. Сонгон шалгаруулалтад оролцох эрх бүхий этгээд нь компани, судалгааны хүрээлэн, эрдэм шинжилгээний байгууллага, ТББ, эсвэл тэдгээрийн хоорондын түншлэл байна. Сонгон шалгаруулалтад оролцогчийг өгөгдөл, мэдээлэл нэгтгэн боловсруулах, судалгааны арга техникийн дагуу асуумж, шалгуур боловсруулах, судалгаа хийх, судалгааны үр дүнд дүн шинжилгээ хийх, тайлагнах зэрэг олон чиглэлээр туршлагатай байхыг шаардана. Мөн тухайн этгээд нь сүүлийн гурван жилийн (2021, 2022, 2023 он) хугацаанд өгөгдөл мэдээлэл цуглуулах, нэгтгэн боловсруулахтай холбоотой үйлчилгээ үзүүлэх доод тал нь 1 гэрээг үндсэн гүйцэтгэгчийн хувьд гүйцэтгэж, дуусгасан байх ба үүнийг дараах баримт ирүүлж нотолно. Үүнд:
- (i) Гарын үсэг зурсан гэрээ;
 - (ii) Өмнөх үйлчлүүлэгч, ажил олгогчийн тодорхойлох албан бичгийн хуулбар;
 - (iii) Ажил хүлээлцэх акт, түүнтэй адилтгах баримт бичиг;
 - (iv) Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар.
- 6.2. **БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН:** Тухайн хуулийн этгээд нь гэрээнд заасан ажил үйлчилгээг, заасан хугацаанд, Захиалагчийн сэтгэл ханамжид нийцэхүйц хийж гүйцэтгэхэд шаардлагатай хүний нөөцийг өөрөө тодорхойлно. Гэвч энэхүү Төслийн хүрээнд нийлүүлсэн тоног төхөөрөмжийн үр ашгийн судалгааг хийж гүйцэтгэх ажлын багт дараах мэргэжилтнүүдийг заавал байхыг шаардана.

6.2.1. **Багийн удирдагч:** Статистик, мэдээлэл, өгөгдлийн чиглэлээр их дээд сургууль төгссөн, судалгааны асуумж боловсруулах, судалгаа хийж, мэдээллийг боловсруулж, үр дүнд дүн шинжилгээ хийх чиглэлээр 8-аас доошгүй жилийн ажлын туршлагатай байхыг шаардахаас гадна доорх ур чадварыг эзэмшсэн байвал зохино. Үүнд:

- Хамтрагч талуудтай харилцах харилцааны ур чадвар сайтай, багийг үр дүнтэйгээр удирдан чиглүүлэх, манлайлах;
- Аудитын дүгнэлтэд үндэслэн асуудлыг тодорхойлох, эрсдэлийг үнэлж, шийдвэрлэх арга замыг санал болгон, дэвшүүлэх;
- Багийг томилолтоор ажиллах хугацаанд зайнаас удирдан чиглүүлэх чадвартай, заасан хугацаа, төсвийн хүрээнд ажлын даалгаврыг төлөвлөх, зохион байгуулах, гүйцэтгэх.

Эдгээрийг (i) CV, (ii) диплом, гэрчилгээний хуулбар ирүүлж нотолно.

6.2.2. **Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер / шинжээч:** Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер эсхүл цахилгааны болон электроникийн инженер мэргэжилтэй байх. Эмнэлгийн нарийн мэргэжлийн тоног төхөөрөмжтэй харьцан ажиллах тул бакалаврын зэргээс өндөр зэрэгтэй бол давуу тал болно. Дүрс оношилгооны анхан шатны төхөөрөмжөөс эхлээд лабораторийн бүх төрлийн тоног төхөөрөмжтэй доод тал нь 5 жил ажилласан туршлагатай, эсхүл эрүүл мэндийн тоног төхөөрөмжийн хяналт үнэлгээний чиглэлээр 5-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх. Мөн эмнэлгийн нарийн мэргэжлийн техникийн баримт бичиг, засвар үйлчилгээний бүртгэл, гүйцэтгэлийн баримт мэдээллийг ойлгох, үнэлэх, тоног төхөөрөмжид ашиглалтад үнэлгээ хийх технологийг ашиглах чадвартай байна. Эдгээрийг (i) CV, (ii) диплом, гэрчилгээний хуулбараар нотолно.

6.2.3. **Эмнэлгийн тоног төхөөрөмжийн техникийн ажилтан:** Эмнэлгийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний чиглэлээр 2-оос доошгүй жил эмнэлгийн орчинд ажилласан туршлагатай, биоанагаах эсвэл эмнэлгийн цахилгааны техникчийн мэргэжилтэй бол давуу тал болно. Тоног төхөөрөмжид засвар үйлчилгээний бүртгэл, гүйцэтгэлийн баримт мэдээллийг ойлгох, үнэлэх, тоног төхөөрөмжид ашиглалтад үнэлгээ хийх чадвартай байхыг шаардана. Эдгээрийг (i) CV, (ii) диплом, гэрчилгээний хуулбар ирүүлж нотолно.